



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завханмандал сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА/2023/145/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2024 он

Дарга,

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Жалбаа

Утас: 89330330

Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.01.30 № 24

талай _____ -ны № _____ -т

ЗАВХАНМАНДАЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ө.ДУЛАМСҮРЭН-Д

ӨӨРЧЛӨЛТГҮЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завханмандал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Завханмандал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Завханмандал сумын нь 2023 онд сум үүсэн байгуулагдсаны түүхэн 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Завханмандал сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, босоо тогтолцоотой байгууллагын алба хаагчдад урамшуулал, томилолт олгосон, бараа материалын тайланг нэр төрлөөр төрөлжүүлэн тайлагнаагүй зэрэг алдаа, зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Завханмандал сумын Засаг даргын Тамгын газар нь аймгийн ИТХ, Завхан аймаг дахь төрийн аудитын газраас хамтран зохион байгуулсан "Шилэн дансны тухай хуулийн

013080914

хэрэгжилт" аяны хүрээнд хуулийн хэрэгжилтийг сайн хэрэгжүүлсэн байгууллагаар шалгарч, өргөмжлөлөөр шагнуулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д. БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2023 оны 12 -р сарын 31
өдөр

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	27,167,000.00	16,193,217.54
33	АВЛАГА		518,417.54
33500	Бусад авлага		518,417.54
33510	Байгууллагаас авах авлага		518,417.54
35	БАРАА МАТЕРИАЛ	27,167,000.00	15,674,800.00
35400	Хангамжийн материал	17,807,000.00	15,674,800.00
35410	Бичиг хэргийн материал	3,246,400.00	3,301,400.00
35420	Аж ахуйн материал	884,300.00	493,000.00
35470	Бусад хангамжийн материал	13,676,300.00	11,880,400.00
35600	Мал амьтад	9,360,000.00	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	967,689,386.61	1,180,237,749.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	967,689,386.61	1,180,237,749.13
39200	Биет хөрөнгө	959,279,386.61	1,137,191,749.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	568,185,135.92	568,185,135.92
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	-73,324,388.07	-90,072,372.63
39203	Авто-тээврийн хэрэгсэл	62,600,000.00	267,044,594.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	-53,547,121.56	-263,791,715.52
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	141,530,780.47	160,406,513.50
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	-95,714,105.95	-91,111,201.22
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,424,925.52	58,202,340.00
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	-47,344,916.16	-39,237,700.56
39214	Бусад үндсэн хөрөнгө	763,823,217.17	971,790,149.17
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	-369,354,140.73	-404,223,993.53
39300	Биет бус хөрөнгө	8,410,000.00	43,046,000.00
39301	Програм хангамж	3,502,000.00	7,305,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	-2,602,000.00	-2,505,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,510,000.00	38,246,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	994,856,386.61	1,196,430,966.67
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	994,856,386.61	1,196,430,966.67
51	Засгийн газрын хувь оролцоо	994,856,386.61	1,196,430,966.67
51101	-Төрийн	911,194,853.89	911,194,853.89
51200	Хуримтлагдсан үр дүн	-53,875,327.74	147,699,252.32

51210	Өмнөх үеийн үр дүн	-263,027,861.83	-53,875,327.74
51220	Тайлант үеийн үр дүн	209,152,534.09	201,574,580.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	137,536,860.46	137,536,860.46
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	994,856,386.61	1,196,430,966.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2023 оны 12 -р сарын 31 өдөр

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	604,395,434.92	790,722,931.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	181,830,834.92	245,560,932.00
1200	Нийтлэг татварын бус орлого	181,830,834.92	245,560,932.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	172,470,834.92	239,005,932.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	9,360,000.00	6,555,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	422,564,600.00	545,161,999.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	136,104,500.00	87,139,999.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	136,104,500.00	87,139,999.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	286,460,100.00	458,022,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	286,460,100.00	458,022,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	395,242,900.83	589,148,350.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	395,242,900.83	589,148,350.94
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	390,559,011.67	586,764,068.33
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	182,858,130.73	319,874,429.70
210101	Үндсэн цалин	152,652,635.73	210,264,050.70
210102	Нэмэгдэл	29,540,327.00	97,534,989.00
210104	Урамшуулал	665,168.00	12,075,390.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,499,900.00	40,198,900.00
210201	Тэтгэврийн даатгал	15,523,900.00	27,335,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,659,400.00	3,215,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,420,000.00	2,572,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	357,000.00	643,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,539,600.00	6,431,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,117,400.00	32,801,574.15
210301	Гэрэл, цахилгаан	2,194,752.00	3,608,794.15
210302	Түлш, халаалт	32,922,648.00	29,192,780.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,154,560.20	40,857,393.00
210401	Бичиг хэрэг	1,599,170.00	3,116,680.00

210402	Тээвэр, шатахуун	18,954,330.00	17,502,513.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,344,000.00	2,136,000.00
210408	Бараа материал актласны зардал	3,257,060.20	18,102,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	988,200.00	1,086,000.00
210604	Урсгал засвар	988,200.00	1,086,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,880,000.00	10,314,289.00
210702	Дотоод албан томилолт	6,880,000.00	10,314,289.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,861,050.00	1,859,841.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,907,000.00	1,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	290,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,250.00	72,284.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.00	203,400.00
210807	Газрын төлбөр	138,300.00	94,132.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	109,199,770.74	139,771,641.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,920,130.11	58,510,672.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	303,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	66,976,240.63	80,957,569.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,683,889.16	2,384,282.61
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,683,889.16	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	536,089.16	
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,147,800.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		2,384,282.61
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		2,384,282.61
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	209,152,534.09	201,574,580.06
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	209,152,534.09	201,574,580.06

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 12 -р сарын 31 өдөр

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	422,564,600.00	545,161,999.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	422,564,600.00	545,161,999.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	136,104,500.00	87,139,999.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	136,104,500.00	87,139,999.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	286,460,100.00	458,022,000.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	286,460,100.00	458,022,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	321,184,600.00	490,661,999.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	321,184,600.00	490,661,999.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	316,500,710.84	488,277,716.39
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	182,858,130.73	320,392,847.24
210101	Үндсэн цалин	152,652,635.73	210,782,468.24
210102	Нэмэгдэл	29,540,327.00	97,534,989.00
210104	Урамшуулал	665,168.00	12,075,390.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,499,900.00	40,198,900.00
210201	Тэтгэврийн даатгал	15,523,900.00	27,335,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,659,400.00	3,215,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,420,000.00	2,572,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	357,000.00	643,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,539,600.00	6,431,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,117,400.00	32,801,574.15
210301	Гэрэл, цахилгаан	2,194,752.00	3,608,794.15
210302	Түлш, халаалт	32,922,648.00	29,192,780.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,678,000.00	20,746,577.00
210401	Бичиг хэрэг	1,376,670.00	2,781,680.00
210402	Тээвэр, шатахуун	18,957,330.00	15,828,897.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,344,000.00	2,136,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	988,200.00	1,086,000.00
210604	Урсгал засвар	988,200.00	1,086,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,880,000.00	10,314,289.00
210702	Дотоод албан томилолт	6,880,000.00	10,314,289.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,046,050.00	1,859,841.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,092,000.00	1,200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	290,025.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,250.00	72,284.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.00	203,400.00
210807	Газрын төлбөр	138,300.00	94,132.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,433,030.11	60,877,688.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,129,630.11	60,574,288.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	303,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,683,889.16	2,384,282.61
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,683,889.16	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	536,089.16	

213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,147,800.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		2,384,282.61
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		2,384,282.61
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	101,380,000.00	54,500,000.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	101,380,000.00	54,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	101,380,000.00	54,500,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	101,380,000.00	54,500,000.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	101,380,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	101,380,000.00	54,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	101,380,000.00	-54,500,000.00
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 12 -р сарын 31 өдөр

/төгрөг өөр/

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	911,194,853.89	137,536,860.46	-271,399,937.72	777,331,776.63
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			8372075.89	8372075.89
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	911,194,853.89	137,536,860.46	-263,027,861.83	785,703,852.52
9	Тайлант үеийн үр дүн			209,152,534.09	209,152,534.09
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	911,194,853.89	137,536,860.46	-53,875,327.74	994,856,386.61
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	911,194,853.89	137,536,860.46	-53,875,327.74	994,856,386.61
19	Тайлант үеийн үр дүн			201,574,580.06	201,574,580.06
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	911,194,853.89	137,536,860.46	147,699,252.32	1,196,430,966.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/(УТ)

2023 оны 12 -р сарын 31 өдөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				Дүнгээр	%
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	458,022,000.00	455,638,428.39	2,383,571.61	99.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	458,022,000.00	455,638,428.39	2,383,571.61	99.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	458,022,000.00	455,638,428.39	2,383,571.61	99.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	321,590,700.00	320,392,847.24	1,197,852.76	99.44
210101	Үндсэн цалин	237,696,400.00	210,782,468.24	26,913,931.76	85.18
210102	Нэмэгдэл	83,894,300.00	97,534,989.00	13,640,689.00	50.48
210104	Урамшуулал		12,075,390.00	12,075,390.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,198,900.00	40,198,900.00		100.00
210201	Тэтгэврийн даатгал	27,335,200.00	27,335,200.00		100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,215,900.00	3,215,900.00		100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,572,800.00	2,572,800.00		100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	643,200.00	643,200.00		100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,431,800.00	6,431,800.00		100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,816,000.00	32,801,574.15	14,425.85	99.98
210301	Гэрэл, цахилгаан	3,626,900.00	3,608,794.15	18,105.85	99.50
210302	Түлш, халаалт	29,189,100.00	29,192,780.00	-3,680.00	100.01
2104	Хангамж, бараа материалын зардал	20,351,800.00	20,350,866.00	934.00	99.99
210401	Бичиг хэрэг	2,209,300.00	2,781,680.00	-572,380.00	150.82
210402	Тээвэр, шатахуун	15,492,300.00	15,433,186.00	59,114.00	97.69
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,650,200.00	2,136,000.00	514,200.00	42.69
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,086,000.00	1,086,000.00		100.00
210601	Багаж, техник хэрэгсэл				
210604	Урсгал засвар	1,086,000.00	1,086,000.00		100.00
2107	Томилолт, зочны зардал	7,110,200.00	7,110,000.00	200.00	100.00
210702	Дотоод албан томилолт	7,110,200.00	7,110,000.00	200.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнийн төлбөр, хураамж	3,030,000.00	1,859,841.00	1,170,159.00	68.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200,000.00	1,200,000.00		100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	560,000.00		560,000.00	

210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	290,025.00	179,075.00	61.83
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	72,284.00	155,416.00	31.75
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73,800.00		73,800.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.00	203,400.00		100.00
210807	Газрын төлбөр	138,300.00	94,132.00	44,168.00	68.06
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	157,700.00		157,700.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,838,400.00	31,838,400.00		100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,535,000.00	31,535,000.00		100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	303,400.00		100.00
12200	Тусламжийн орлого	458,022,000.00	455,638,428.39	-	102.14
				34,616,428.39	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 12 -р сарын 31 өдөр

/төгрөгөөр/(НС)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)	87,139,288.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	87,139,288.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	87,139,288.00
2104	Хангамж, бараа материалын зардал	395,711.00
210402	Тээвэр, шатахуун	395,711.00
2107	Томилолт, зочны зардал	3,204,289.00
210702	Дотоод албан томилолт	3,204,289.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,539,288.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,539,288.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)	87,139,288.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	87,139,288.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	87,139,288.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	87,139,288.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завханмандал сумын Засаг даргын тамгын газар нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр,

төслийг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь 2023 онд 4 зорилтын хүрээнд 45 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилт 96.9 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Завханмандал сумын ЗДТГ нь үйл ажиллагаандаа Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завханмандал сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нутгийн захиргааны байгууллагууд нь нийтлэг НББ-ын бодлогын баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завханмандал сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 201.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			

Авлага	0	518.4	-518.4
Бараа материал	27,167.0	15,674.8	11,493.2
Үндсэн хөрөнгө	967,689.4	1,180,237.7	-212,548.3
Нийт хөрөнгө	994,856.4	1,196,430.9	-201,574.5
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	994,856.4	1,196,430.9	-201,574.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	994,856.4	1,196,430.9	-201,574.5

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

- ✓ Авлага дансны үлдэгдэл өссөн нь НДШ-ийн авлага үүссэн
- ✓ Бараа материалын үлдэгдэл буурсан нь эхний үлдэгдлээс 11.5 сая төгрөгийн бараа материалын зарцуулалт хийсэн
- ✓ Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өссөн нь хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл арга хэмжээний хүрээнд 239.0 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан, балансаас 212.1 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэн шилжүүлэн авсан, төсвийн хөрөнгөөр 54.5 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн зэрэгтэй тус тус холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 100.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглал хөтөлбөрийн үндсэн болон баг хорооны үйл ажиллагаа, мэдээлэл сурталчилгаа, орон нутгийн нөөц хөрөнгө /нөөц сан/, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргэх гэсэн 5 арга хэмжээг 488.0 сая төгрөгөөр орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 458.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 2.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, гүйцэтгэл 99.5 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	379,420.6	358,158.6	21,262.0	
2	Баг, хорооны үйл ажиллагаа	50,866.6	69,744.7	-18,878.1	
3	Мэдээлэл сурталчилгаа	1,200.0	1,200.0	0	
4	Засаг даргын нөөц сан	25,000.0	25,000.0	0	
5	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	1,535.0	1,535.0	0	
	ДҮН	458,022.2	334,703.0	2,383.9	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр 87.1 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн бөгөөд энэ нь бэлчээр ашигласны төлбөр 1.3 сая, төрийн банкны түрээсийн орлого 3.1 сая төгрөг, өмнө оны үлдэгдэл 4.1 сая төгрөг, аймгийн ОНХС-ийн сангаас эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилт 55.0 сая төгрөг болон бусад орлого 23.6 сая төгрөг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Сумын хэмжээнд тусгайлан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завханмандал сумын ЗДТГ -ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Жалбаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Завханмандал сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 3/14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгөөр сонгож 994.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 11.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгө 1,196.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 17.9 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй бөгөөд аудитаар төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, хууль журамд тусгагдаагүй урамшуулал олгосон зэрэг зөрчил илэрсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Завханмандал сумын ЗДТГ-ын шилэн дансны мэдээллийг анхан шатны баримттай тулган шалгахад хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг тухай бүр мэдээлсэн байна. Мөн ИТХ, Завхан аймаг дахь төрийн аудитын газраас хамтран зохион байгуулсан “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” аяны хүрээнд хуулийн хэрэгжилтийг сайн хэрэгжүүлсэн байгууллагаар шалгарч, өргөмжлөлөөр шагнуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа зөрчил илрээгүй

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завханмандал сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийхээр төлөвлөсөн хэдий ч тус байгууллага аудитад шаардлагатай баримт материалыг ирүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн аудитаар Шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны цалин олгосон 2.5 сая төгрөгийн, Шилэн дансны мэдээллийг тухай бүр мэдээлээгүй 131.9 сая төгрөгийн, Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт бус зарцуулсан 6.7 сая төгрөгийн, дулааны гэрээ шинэчилж хийгээгүй 9-12 сар хүртэлх төлбөр илүү шилжүүлсэн 3.8 сая төгрөгийн, нийт 144.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	6,263.5	2	6,263.5	100
Зөвлөмж	2	138,584.6	2	138,584.6	100
Нийт дүн	4	144,848.1	4	144,848.1	100

Шийдвэрийн биелэлтийг FAS системд бүртгэсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 85.8 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан байна. Үүнд:

- ✓ Төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийг шууд зардлаар бүртгэсэн, дансны бичилт буруу хийсэн 54.6 сая төгрөгийн,
- ✓ Тооцоо нийлсэн актаар баталгаажсан НДШ-ын авлагыг данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан 0.5 сая төгрөгийн,
- ✓ Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй газрыг данс бүртгэлд тусгаагүй 30.7 сая төгрөгийн алдаа байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 17.2 сая төгрөгийн зөрчил² илэрсний 0.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 16.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Байгаль орчны бохирдлыг арилгах сэг зэм устгах зориулалтаар Засаг даргын орлогчийн дансанд шилжүүлсэн шатахууны зардлыг төсвөөс давхардуулан төлсөн 0.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрээр сумын Засаг даргад 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгосон 1.5 сая төгрөгийн, босоо тогтолцоотой байгууллагын алба хаагчдад урамшуулал, томилолт олгосон 2.6 сая төгрөгийн, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан 3.3 сая төгрөгийн, бараа материалын тайланг нэр төрлөөр нь төрөлжүүлж гаргаагүй, анхан шатны баримт бүрдүүлэлт, баримтын эмх цэгц хангалтгүй 9.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөх алдаа, зөрчил илрээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/									
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
Төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийг шууд зардлаар бүртгэсэн, дансны бичилт буруу хийсэн, байгууллагын эзэмшилд бүртгэлтэй газрыг данс бүртгэлд тусгаагүй	2	85,291.0	1	30,736.0	1	54,555.0	2	85,291.0		
Тооцоо нийлсэн актаар баталгаажсан НДШ-ын авлагыг данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан	1	518.4	1	518.4			1	518.4		
ДҮН	3	85,809.4	2	31,254.4	1	54,555.0	3	85,809.4		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгаль орчны бохирдлыг арилгах сэг зэм устгах зориулалтаар Засаг даргын орлогчийн дансанд шилжүүлсэн шатахууны зардлыг төсвөөс давхардуулан төлсөн	1	748.8	1	748.8								
босоо тогтолцоотой байгууллагын алба хаагчдад урамшуулал, томилолт олгосон	1	2,628.6			1	2,628.6						
бараа материалын тайланг нэр төрлөөр нь төрөлжүүлж гаргаагүй, анхан шатны баримт бүрдүүлэлт, баримтын эмх цэгц хангалтгүй	1	9,081.9			1	9,081.9						
ДҮН	3	12,459.3	1	748.8	2	11,710.5						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				/мянган төгрөгөөр/	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрээр сумын Засаг даргад 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгосон	1	1,511.3			1	1,511.3		
Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан	1	3,260.5			1	3,260.5		
Дүн	2	4,771.6			2	4,771.6		
Нийт дүн	2	4,771.6			2	4,771.6		



БОЛОВСРУУЛСАН : АХЛАХ АУДИТОР

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ЖАЛБАА

Д.БАТ-УНДРАА

Х.БОЛДБААТАР

2024.01.30

2024.01.30

2024.01.30